

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЭЛТСҮҮДИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
ТАЙЛАН

2023 оны 04 дүгээр сарын 12

Номгон

Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгон хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөө, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, сум, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагууд, аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдийн 2022 оны жилийн үйл ажиллагааг үнэлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын 6 хэлтэс, 1 штаб хамрагдсан.

Хэлтсүүдийн үнэлгээг журмын нэгдүгээр хавсралтаар батлагдсан цаглавраар 2022 оны 12 дугаар сарын 10-наас 2023 оны 02 дугаар сарын 10-ны хооронд тайлагнасан дараах 11 төрлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланд хийсэн болно. Үүнд:

- 1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- 2.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- 3.Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт;
- 4.Дэд хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;
- 5.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт;
- 6.Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт;
- 7.Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт;
- 8.Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт;
- 9.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт зэрэг 9 тайланг Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангаар хүлээн авч, үнэлгээ хийсэн.

Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээг Байгууллагын үнэлгээний багийн дүнгээр тус тус үнэллээ.


Журмын дагуу зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлгээнд тооцох байсан хэдий ч хэлтсүүдээс зөвлөмжийн хэрэгжилт ирээгүй учир энэ удаагийн үнэлгээнд оруулаагүй болно.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдийн үйл ажиллагааны үр дүнг харьяа агентлагийн нэгдсэн дүнгийн хамт танилцуулья.

Нэг. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс:

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн тайлангуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 85.76 хувьтай үнэлэгдлээ.

Хэлтсийн 2022 оны бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг доорх графикт үзүүлэв.



Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн харьяа агентлагуудын 2022 оны үйл ажиллагааны нэгдсэн дүн болон тайлангийн ирцийг дараах хүснэгтэд нэгтгэн харуулбал:

Д/Д	Агентлагийн нэр	Дундаж үнэлгээ	Тайлангийн тоо			
			Тайлагнавал зохиц	Тайлан ирүүлсэн	Хугацаа хоцорсон	Тайлагнаагүй
1	2	3	4	5	6	7
1	Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газар	58.50	13	10	0	3
2	Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар	87.29	12	12	0	0
	Дүн/дундаж	72.89	25	22	0	3

Хэлтсийн тайланд үнэлгээ хийхэд дараах зөрчил, дутагдал гарч байна. Үүнд:

1.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн аймгийн нэгдсэн тайланг журмын 4.4 дэх заалтын дагуу Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж нэгтгэн ирүүлэх заалтын хүрээнд аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд аймгийн 2022 оны жилийн эцсийн 4 нэгдсэн тайланг дутуу тайлагнасан. Үүнд:

1.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны нэгдсэн тайлан ирүүлээгүй.

1.2.Дэд хөтөлбөрийн нэгдсэн тайланд 2 дэд хөтөлбөр (Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх, Сан хөмрөгийн баримтыг иж бүрэн нягтлан шалгах хөтөлбөр)-ийн хэрэгжилт тайлагнаагүй.

1.3.Аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрийн нэгдсэн тайлан ирүүлээгүй.

1.4.Аймгийн Засаг даргын захирамжийн нэгдсэн тайланд 21 заалт дутуу тайлагнасан учир нэгдсэн тайлангийн үнэлгээ хийх боломжгүй нөхцөл байдал үүссэн.

1.5.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичгийн нэгдсэн тайланд зарцуулсан хөрөнгийг тодорхой тусгаагүй, нотлох баримтыг хавсаргаагүй.

1.6.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн нэгдсэн тайланд хяналтаас хасуулах санал ирүүлээгүй.

2.Аймгийн хэмжээнд бодлого, шийдвэрийг удирдан зохион байгуулах ажил дутагдалтай байна. Тухайлбал:

2.1.Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах нэгдсэн бодлого байхгүйгээс сумд хүний нөөцийн дутагдалд орсон.

2.2.Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангуулах талаар сум, агентлагуудад зохион байгуулсан ажлын үр дүн хангалтгүй.

2.3.Аймгийн Засаг даргын Тамгын газар, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүргийн ялгаа тодорхойгүй байдлаас шалтгаалан аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд Баянхонгор сумын ажлыг сумын нэр заалгүй, аймгийн ажил мэт тусган хэрэгжүүлсэн.

2.4.Аймгийн Засаг даргын захирамжийг утга агуулга ижил төстэй, олон тоогоор гаргаснаар үр дүн, үр нөлөө багатай, чанаргүй захирамж ихэссэн.

2.5.Байгууллагын гүйцэтгэлийн тайланг үнэлэх Үнэлгээний багт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөөгүйгээс Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн тайлан журмын дагуу үнэлэгдээгүй.

3.Аймгийг хөгжүүлэх дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан Утасгүй сүлжээний орчинг бий болгож, төрийн цахим үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлэх, Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх, Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгаа авах, "Төрийн мэргэшсэн албан хаагч" 2022-2026 онд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

4.Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан дараах арга хэмжээнүүд Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.2.6 дахь "нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх зарчим" (хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, батлах, төлөвлөх, хэрэгжүүлэхдээ байгалийн баялаг, түүхий эд, хөрөнгө санхүү, техник технологи, шинжлэх ухаан, инновац, ур чадвартай ажиллах хүчин болон шаардлагатай бусад нөөцийг урьдчилан тооцоолсон төсөв, төсөөллийн дагуу тодорхойлсон хязгаарлалтын хүрээнд тусгах), 6.10.2 дахь санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх шаардлагыг зөрчсөн. Үүнд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын заалны тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэл, Хурлын ажлын албаны ажиллах хэвийн үйл ажиллагааг хангаж, автомашиныг шинэчлэх,

- Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг хийлгэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

- "Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем"-ийн нэмэлт хөгжүүлэлт хийх. Үүнд: 1. "Цахим Баянхонгор" Гар утасны АПП + хөгжүүлэлт 2. Цахим мэдээллийн тайлангийн систем хөгжүүлэлт,

- "Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем"-ийн нэмэлт хөгжүүлэлт хийх. Үүнд: 1. Дашбоард хөгжүүлэлт /Тоон мэдээллийн цахим хяналтын самбар/ 2. Иргэдийн санал, гомдол илгээх систем,

- 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын мэдээллийг цахимжуулах 360 технологид суурилсан гар утасны АПП (iOS, Android) хөгжүүлэх,


– Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний Киоск (өөртөө үйлчлэх) машины систем хөгжүүлэн нэвтрүүлж, төрийн байгууллагууд болон нийтийн үйлчилгээний газруудад байршуулна,

– 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын мэдээллийг цахимжуулах 360 технологид суурилсан программ хангамж хөгжүүлэх зэрэг арга хэмжээнүүд сул төлөвлөлтөөс шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байна.

Хоёр. Хууль эрх зүйн хэлтэс:

Хууль, эрх зүйн хэлтсийн 2022 оны жилийн эцсийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нэгжийн гүйцэтгэлийн үнэлгээ зэргийг нэгтгэн дүгнэхэд 82.83 хувьтай үнэлэгдсэн.

Үнэлгээний дэлгэрэнгүйг доорх графикт үзүүлэв.



Хууль эрх зүйн хэлтсийн харьяа агентлагуудын 2022 оны үйл ажиллагааны нэгдсэн дүн болон тайлангийн ирцийг хүснэгтээр үзүүлбэл:

Д/д	Агентлагийн нэр	Дундаж үнэлгээ	Тайлангийн тоо			
			Тайлаг навал зохих	Тайлан ирүүлсэн	Хугацаа хоцорсон	Тайлагнаа-гүй
1	2	3	4	5	6	7
1	Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	75.37	12	12	1	0
2	Баянхонгор аймгийн Цагдаагийн газар	59.81	12	7	0	2
3	Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	71.76	11	10	0	1
4	Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний алба	58.28	11	10	1	2
	Дүн	66.3	46	39	2	5

Тус хэлтсийн тайлангуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах зөрчил, дутагдал байна.


1.Бодлогын баримт бичиг дэх зорилт арга хэмжээ, хууль тогтоомжийг аймгийн хэмжээнд нэг мөр мөрдүүлэх, салбар хоорондын уялдааг хангах зохион байгуулалт сул байдлаас үүдэн

тухайн арга хэмжээ бодит үр дүнд хүрэхгүй, бүрэн гүйцэтгэлгүй, зөрүүтэй тайлагнах шалтгаан болж байна. Тухайлбал: Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.1-ийн 1.Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн тоог бууруулах, 2.Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах, 4.Мал хулгайлах гэмт хэргийн тоог бууруулах гэх мэт арга хэмжээний хэрэгжилтийг зөвхөн Цагдаагийн газрын тайланд үндэслэн тайлагнаж, сумдын хийсэн ажлын үр дүнг нэгтгэн тайлагнахгүй, гэмт хэрэг зөрчлийн тоо өссөн байна.

2.Харьяа агентлагуудыг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллаагүйгээс Цагдаагийн газар, Шүүхийн шинжилгээний алба жилийн эцсийн тайлангаа дутуу тайлагнасан байна.

Гурав. Нийгмийн бодлогын хэлтэс:

Хэлтсийн 2022 оны жилийн эцсийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 86.23 хувьтай байна. Дэлгэрэнгүйг доорх зурагт үзүүлэв.



Хэлтсийн харьяа байгууллагуудын 2022 оны үйл ажиллагааны үнэлгээ, тайланг дараах хүснэгтэд үзүүлээ.

Д/д	Агентлагийн нэрс	Дундаж үнэлгээ хувиар	Тайлангийн тоо			
			Тайлагнавал зохих	Тайлан ирүүлсэн	Хугацаа хоцорсон	Тайлагнаагүй
1	2	3	4	5	6	7
1	Биеийн тамир, спортын газар	90.65	12	11	1	1
2	Боловсрол, шинжлэх ухааны газар	75.27	13	12	0	1
3	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	71.04	13	13	2	0
4	Нийгмийн даатгалын хэлтэс	70.61	12	10	0	2
5	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	64.57	12	10	0	2
6	Соёл, урлагийн газар	36.52	13	9	3	4
7	Эрүүл мэндийн газар	72.58	12	11	0	1
8	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	50.86	11	7	0	4

1	2	3	4	5	6	7
9	Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	23.7	10	5	0	5
	Дүн	61.76	108	88	6	20

Тус хэлтсийн болон харьяа байгууллагуудын тайлангуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах зөрчил, дутагдал байна.

1.Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дараах арга хэмжээнүүд хэрэгжилт удаашралтай, хангалтгүй байна.

– Ревматологийн эмчийг бэлтгэх, бодлогоор дэмжих, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

– "Бага насны хүүхдийн цогц хөгжил"-ийг дэмжих стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх

– Иргэдийн гар дээр байгаа баримтат өвийг бүртгэх

– Бага насны хүүхдийн хоол үйлдвэрлэлийн орчны сайжруулах

– "Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөрийн удирдлагын болон хэрэгжүүлэгч багуудын ажлын уялдаа холбоог сайжруулах

– Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах

– Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Жендэрийн салбар хороо, дэд хороодын гишүүдийн чадавхийг нэмэгдүүлэх


– Монголын гэр бүл судлаачид, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааг өргөжүүлж техникийн туслалцааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх

– Хөдөлмөр зусланг ажиллуулах арга хэмжээнүүд үр дүнгүй байна.

2.Салбарын хэмжээнд зохион байгуулсан ажлын үр дүнг бус явцыг дэлгэрэнгүй нуршсан, зарцуулсан хөрөнгийн дүн, эх үүсвэрийг тодорхой тусгаагүй, нотлох баримт хавсаргаагүй, аймгийн хэмжээнд нэгтгээгүй, зөвхөн нэг салбарын мэдээллээр тайлагнаж байна. Тухайлбал: Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022 оны 7 дугаар тогтоолын хэрэгжилтийг зөвхөн Боловсрол, шинжлэх ухааны газрын хэрэгжилтээр тайлагнаж сумд, нутгийн захиргааны бусад байгууллагуудын хийсэн ажлыг нэгтгэлгүй тайлагнасан байна.

Дөрөв. Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс:

Хэлтсийн 2022 оны жилийн эцсийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 89.34 хувьтай байна.



Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтсийн харьяа агентлагуудын 2022 оны жилийн эцсийн тайлангийн нэгдсэн дүнг дараах хүснэгтэд нэгтгэв.

Д/д	Агентлагийн нэр	Дундаж үнэлгээ	Тайлангийн тоо			
			Тайлагна вал зохих	Тайлан ирүүлсэн	Хугацаа хоцорсон	Тайлаг-наагүй
1	2	3	4	5	6	7
1	Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	70.75	13	12	0	1
2	Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	79.22	13	12	0	1
3	Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар	75.44	13	13	0	0
4	Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	70.27	12	11	0	1
5	Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газар	70.96	12	11	0	1
6	Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	87.43	13	13	0	0
	Дүн	75.68	76	72	0	4

Агентлагууд цахим тайланг хугацаанд нь тайлагнасан боловч зөвлөмжийн хэрэгжилт ирүүлээгүй байна.

Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтсийн харьяа төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн тайланг нэгтгэн дүгнэлээ.

Д/д	Агентлагийн нэр	Дундаж үнэлгээ	Тайлангийн тоо			
			Тайлагна вал зохих	Тайлан ирүүлсэн	Хугацаа хоцорсон	Тайлаг-наагүй
1	2	3	4	5	6	7
1	Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	70.75	10	9	0	1
2	Автотээврийн төв	33	11	5	0	5
3	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	70.26	11	10	0	1
4	Баянхонгор Эрчим хүч ЦТХХК	72.35	12	10	0	2
5	Сум дундын ойн анги	66	12	11	0	1
6	Цэвэр хот ОНӨААТҮГ	82.28	12	12	0	0
7	Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨ төсөвт байгууллага	70.1	12	11	0	1
8	Чандмань-Баянхонгор ХК	83.28	12	11	0	1
9	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ОНӨҮГ	74.66	9	9	0	0
	Дүн	69.18	101	88	0	12

Тус хэлтсийн болон харьяа байгууллагуудын тайлангуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах зөрчил, дутагдал байна.

1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дараах зорилтууд удаашралтай, хэрэгжилт хангалтгүй байна.

– Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ.

– Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулна.

– Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.

– Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулна.

– Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

– Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно.

– Аймаг, сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог боловсруулах үйлдвэрийг үе шаттайгаар байгуулна.

– Эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжиж, шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.

– Төр, хувийн хэвшлийн оролцоотой “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

– Махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барьж ажлын байрыг нэмэгдүүлнэ.

– Газрын байгалийн тогтоц, нуга, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, Байдраг голыг түшиглэн олон зориулалтаар ашиглах усан сан байгуулна.

– Хүлэмжийн хийн ялгарлыг 10 хувиар бууруулна.

– Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэнэ.

– Томоохон голуудад төмөр бетонон гүүр барих

– Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэх

– Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч нөхөрлөл, хоршоо болон иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах.

– Баялгийн сан байгуулж, төсөл хөтөлбөрийг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх

2.Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлт байхгүй нь үнэлгээ хийхэд хүндрэл учруулж байна.

3.Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд дараах алдаа, дутагдал байна.

3.1.Ижил утгатай зорилт арга хэмжээг давхардуулан тусгасан. Тухайлбал: Гурван бүсийн цогцолбор цэцэрлэгт хүрээлэнгийн их засварын ажлыг хийх арга хэмжээг 5.1.19 болон 5.1.39 дэх арга хэмжээтэй; 5.1.30 дахь Оготнотой булаг орчмын тоглоомын талбайн 55 автомашины зогсоол арга хэмжээ нь 5.1.40 дэх Хүүхэд залуучуудын спорт цогцолбор амралт зугаалгын бүсийн тохижилт арга хэмжээтэй, 4.1.1 дэх "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний арга хэмжээ 5.1.41 дэх арга хэмжээтэй, 4.1.13 дахь Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах арга хэмжээ 5.1.27 дахь Баянхонгор аймгийн төвд шинэ суурьшлын бүс бий болж байгаатай холбоотойгоор ус

хангамжийн эх үүсвэрт 5 дахь худаг гаргах, 5.1.2 дахь Аймгийн төв доторх эвдэрсэн 1000м2 талбайд замын нөхөөс хийх арга хэмжээ 5.1.31 дэх Аймгийн төв доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх арга хэмжээтэй, 5.1.12 дахь аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээг хийх арга хэмжээ 5.1.42 дахь Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажил арга хэмжээтэй тус тус давхардсан утгыг илэрхийлэн төлөвлөгдсөн байна.

3.2.Баянхонгор сумын ажлыг сумын нэр заалгүй аймгийн ажил мэт томъёолсон. Тухайлбал: 2.6.7. Эрдэнэмандал хайрханы бурханы засвар, тохижилтын ажлыг хийх, 4.1.22. Төв зам дагуу хогийн сав байрлуулах, 4.1.23. Төв зам дагасан хайлаасан хашлагын дагуу буй явган хайсыг авч амчуулын баруун талын замын дагасан нарс моднуудыг хаших, 4.1.13. Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах, 5.1.1. Арван мянгатын хатуу хучилттай 1.2 км зам дагуу явган хүний зам барих, босоо бордюр хийх, 5.1.3. Аюулгүйн тойргоос Нэгдсэн эмнэлгийн баруун хойд уулзвар хүртэл 900 метрт хатуу хучилттай авто замыг шинэчлэх, 5.1.4. Онцгой байдлын газрын уулзвараас Хүнс, хөдөө аж ахуйн газрын урд уулзвар хүртэлх 750 метр замд хатуу хучилттай авто зам барих, 5.1.5. Есөн-Эрдэнэ захын баруун талаас Хонгор хотхон хүртэлх зам дагуу явган хүний зам хийх, 5.1.19. Гурван бүсийн цогцолбор цэцэрлэгт хүрээлэнгийн их засварын ажлыг хийх, 5.1.34. Хуучнаар 12 дугаар байрны баруун талын хэсгийн явган зам хэмээн томъёолсон байна.

3.3.Нэг арга хэмжээний төсөв, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг задалж төлөвлөсөн. Тухайлбал: 7.1.6 дахь арга хэмжээнд

-1-д “Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем”-ийн нэмэлт хөгжүүлэлт хийх. Үүнд: 1.Үндсэн сайтын нэмэлт хөгжүүлэлт, 2.Сумдын сайтын нэмэлт хөгжүүлэлт,

-2-д “Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем”-ийн нэмэлт хөгжүүлэлт хийх. Үүнд: 1.Дашбоард хөгжүүлэлт /Тоон мэдээллийн цахим хяналтын самбар/, 2. Иргэдийн санал гомдол илгээх систем,

-3-д “Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем”-ийн нэмэлт хөгжүүлэлт хийх. Үүнд: 1.“Цахим Баянхонгор” Гар утасны АПП + хөгжүүлэлт, 2. Цахим мэдээллийн тайлангийн систем хөгжүүлэлт

7.1.7 дахь арга хэмжээнд:

-1-д 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын мэдээллийг цахимжуулах 360 технологид суурилсан программ хангамж хөгжүүлэх;

-2-д 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын мэдээллийг цахимжуулах 360 технологид суурилсан гар утасны АПП (iOS, Android) хөгжүүлэх хэмээн задалж төлөвлөсөн.


3.4.Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй ажлыг тусгасан. Тухайлбал: 2.6.8-д Бөмбөгөр сумд Гэрэлт хөшөө байгуулах, 4.1.18-д Аймгийн хуучин хогийн цэгт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийх, 4.1.20-д Баянхонгор сумын 9 багт хоёрдогч түүхий эд худалдан авах цэгүүдийг байгуулах, . 5.1.8-д Шаардлагатай сумдын шороон замын зураг төсөв боловсруулах, засвар үйлчилгээ хийх (Баянговь, Баянлиг, Баацагаан, Баянцагаан, Шинэжинст, Эрдэнэцогт,Баянөндөр), 5.1.25-д Аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын заалны тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэл, 5.1.27-д Баянхонгор аймгийн төвд шинэ суурьшлын

бүс бий болж байгаатай холбоотойгоор ус хангамжийн эх үүсвэрт 5 дахь худаг гаргах, 7.1.4-д “Нийгмийн салбарын үйлчилгээний хүртээмж, чанар” судалгаа хийх зэрэг арга хэмжээг төсөв, эх үүсвэр тодорхойгүй төлөвлөснөөс хэрэгжээгүй байна.

Тав. Санхүү, төрийн сангийн хэлтэс:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2022 оны жилийн эцсийн тайлангуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 92.43 хувьтай үнэлэгдлээ.

Хэлтсийн 2022 оны бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг доорх зурагт үзүүлэв.




Санхүү төрийн сангийн хэлтсийн харьяа агентлагуудын 2022 оны үйл ажиллагааны нэгдсэн дүнг дараах хүснэгтээс үзнэ үү.

Д/д	Агентлагийн нэр	Дундаж үнэлгээ	Тайлангийн тоо			
			Тайлагнавал зохих	Тайлан ирүүлсэн	Хугацаа хоцорсон	Тайлагнаагүй
1	2	3	4	5	6	7
1.	Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар	75.81	13	12	1	1
2.	Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	87.32	12	12	1	0
3.	Баянхонгор аймгийн Статистикийн хэлтэс	61.92	11	9	0	2
4.	Баянхонгор аймгийн Татварын хэлтэс	87.26	13	13	0	0
	Дүн	78.08	49	46	2	3

Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн 2022 оны жилийн эцсийн тайлангуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 91.60 хувьтай үнэлэгдлээ.


Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн 2022 оны жилийн эцсийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг доорх зурагт үзүүлэв.



Долоо. Цэргийн штаб:

Цэргийн штабын 2022 оны жилийн эцсийн тайлангуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 90.89 хувьтай үнэлэгдлээ.

Цэргийн штабын 2022 оны жилийн эцсийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг доорх зурагт үзүүлэв.



Дүгнэлт:

Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийлээ.

Хэлтсүүдийн 2022 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг доорх хүснэгтээр харуулбал:

5.3.Харьяа агентлагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, журамд заасан хугацаанд тайланг бүрэн авч, аймгийн тайланд нэгтгэн тусгуулах;

Зургаа. Цэргийн штабт:

1.Бодлогын баримт бичиг болон хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг тодорхой, зарцуулсан хөрөнгө, эх үүсвэртэй тайлагнах;

Долоо.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр гарсан алдаа, дутагдлыг засаж залруулах, дахин давтахгүй байхад чиглэгдсэн зөвлөмжийг төлөвлөгөө гарган нэгдсэн удирдлагаар хангаж, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлж ажиллах;

Найм.Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 06 дугаар сарын 30, 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлэх;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Л.МАНДАЛ

